2019 оны 06 сарын 24-ний өдөр Дугаар А/636 Улаанбаатар хот

Техникийн хорооны бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн “б”, 29.2, Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2015 оны 5 дугаар сарын 5-ны өдөр байгуулсан зээлийн хэлэлцээр, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Азийн хөгжлийн банк хооронд 2015 оны 5 дугаар сарын 5-ны өдөр байгуулсан төслийн гэрээг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хэрэгжүүлж буй “Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөл 1”-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор техникийн болон нийтийн тээврийн бодлогын зарим асуудлуудыг хэлэлцэх, шуурхай удирдлагаар хангах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад тулгарч болзошгүй техникийн зохицуулалт, шийдлийг гаргах, шаардлагатай стандартуудыг батлуулах асуудлаар Төсөл хэрэгжүүлэгч байгууллага, Төсөл хэрэгжүүлэх нэгжтэй хамтран ажиллах үүрэг бүхий Техникийн хорооны бүрэлдэхүүнийг хавсралтад заасны дагуу шинэчлэн баталсугай.

2.Техникийн хорооны үйл ажиллагааг яаралтай эхлүүлэн, шуурхай зохион байгуулах, холбогдох мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, хорооны гаргасан техникийн шийдэл, шийдвэрийг Төслийн удирдах хороонд тухай бүр тайлагнаж ажиллахыг Техникийн хороо /Б.Отгонсүх/-нд үүрэг болгосугай.

3. Энэ захирамж батлагдсантай холбогдуулан нийслэлийн Засаг даргын 2018 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн А/633 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ С.АМАРСАЙХАН

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
06 дугаар сарын 24-ний өдрийн
А/636 дугаар захирамжийн хавсралт

“НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ 1”-ИЙН ТӨСЛИЙН ТЕХНИКИЙН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга: -Нийслэлийн Зам, тээврийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч.

Гишүүд: -Зам, тээврийн хөгжлийн яамны Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Тээврийн зохион байгуулалтын хэлтсийн дарга /зөвшилцсөнөөр/;

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга;

-Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газрын дарга;

-Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын дарга;

-Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын дарга;

-Нийслэлийн Замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газрын дарга;

-Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга;

-Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга;

-Нийслэлийн Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын дарга;

-Нийслэлийн Мэдээлэл, технологийн газрын Мэдээллийн сүлжээ, техник, хяналтын хэлтсийн дарга;

-Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албаны Техник, замын хяналтын хэлтсийн дарга /зөвшилцсөнөөр/;

-“Улаанбаатар дулааны сүлжээ” ХК-ийн Ерөнхий инженер /зөвшилцсөнөөр/;

-“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Техникийн бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга /зөвшилцсөнөөр/;

-Харилцаа, холбоо, мэдээллийн технологийн газрын Мэдээллийн Технологийн бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга /зөвшилцсөнөөр/;

	-“Ус сувгийн удирдах газар” ОНӨҮГ-ын Инженерийн бодлогын хэлтсийн дарга.
Нарийн бичгийн дарга:	-“Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөл 1” -ийн Төслийн зохицуулагч /саналын эрхгүй/.